



ШҮҮХИЙН  
ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

“ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН  
БИЕ ДААСАН ЗАГВАР, ХАРЬЦУУЛСАН ТОЙМ  
СУДАЛГАА”

**2013**

**СУДАЛГАА**

ШҮҮХИЙН  
СУДАЛГАА,  
МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

## Агуулга

1. Удиртгал.....	2
2. Шүүхийн Захиргааны байгууллагын бие даасан загвар, чиг үүрэг - пост коммунист улсуудын туршлага.....	7
2.1. Унгар.....	7
2.2. Польш.....	9
2.3. Болгар.....	11
2.4. Словак.....	14
2.5. Литви.....	15
2.6. Эстони.....	17
3. Шүүхийн Захиргааны байгууллагын бие даасан загвар, чиг үүрэг - Европын Холбооны болон бусад өндөр хөгжилтэй улсуудын жишээ, загвар.....	18
3.1. Швед.....	19
3.2. Ирланд.....	20
3.3. Дани.....	21
3.4. Америкийн Нэгдсэн Улс.....	22
3.5. Канад.....	23
4. Дүгнэлт .....	24
5. Эх сурвалж .....	25
6. Хавсралт.....	27



## 1. Удиртгал

1992 оны Үндсэн Хуулийн төсөл боловсруулах, олон шатанд хэлэлцэх, улмаар батлах явцад Шүүхийн Ерөнхий Зөвлөл буюу шүүхийн захиргааны байгууллагын асуудал яригдаж эхэлсэн бөгөөд хууль батлагчдын дунд “Ийм зөвлөл ямар хэрэгтэй юм бэ?, Байвал хэрхэн бүрдэж, хэн толгойлох, юу хийх вэ?” гэх маргаан өрнүүлсээр<sup>1</sup> анхны Шүүхийн Ерөнхий Зөвлөл /ШЕЗ/ байгуулах асуудал дээр хууль тогтоогчид нэгдэж, Үндсэн хуулиндаа суулгаж өгсөн түүхтэй. Мөн 1993 Шүүхийн тухай хуулинд энэ асуудлыг дэлгэрүүлэн зохицуулсан ба тус онд Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилго, үзэл баримтлалаар ШЕЗ нь 12 гишүүнтэйгээр байгуулагдсан<sup>2</sup> нь агуулгийн хувьд манайдаа л шинэ ойлголт байв.

Байгуулагдсанаасаа хойш 20 жилийг ардаа өнгөрөөсөн ШЕЗ нь шүүхийн захиргааны байгууллагын хэд хэдэн загварыг туршин, өөрийн үйл ажиллагаа, шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх үүднээс дорвитой ажлыг хийсээр ирсэн бөгөөд Шүүхийн Ерөнхий зөвлөлийг Улсын дээд шүүхийн хавсрага болгон үйл ажиллагаа явуулдаг байсан загварыг халан одоогийн бүтэцт оруулж, үйл ажиллагаа явуулахаар Шүүхийн Захиргааны Хуулийг 2012 онд баталж, 2013 оны 04 дүгээр сарыг 15-ны өдрөөс эхлэн даган мөрдөж байна.

Энэхүү хууль болон сонгон авсан шүүхийн захиргааны байгууллагын загварын алдаа оноог цаг хугацаа харуулах хэдий ч өдгөөгийн байгаа байдлыг хэрхэн цаашид сайжруулах, гадаад орны туршлагыг судлах зорилгоор энэхүү харьцуулсан судалгааг хийв.

### *Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал*

Шүүхийн захиргаа нь шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг бүтэц бөгөөд Монгол Улсын Үндсэн Хууль, Шүүхийн тухай хуулийн дагуу Шүүхийн захиргааны чиг үүргийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл хэрэгжүүлдэг<sup>3</sup>.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсэгт “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана”, мөн зүйлийн 49.4 дэх хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ” гэж заасан. Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”<sup>4</sup> хэмээн зааснаас гадна мөн МУ-ын Шүүхийн тухай хуулийн 6.5 зүйлд “Шүүх өөрийн захиргаатай байх ба түүний чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тамгын газар хэрэгжүүлэх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна”<sup>5</sup> гэж

<sup>1</sup> Ж. Амарсанаа, Б. Чимид, Р. Мухийт, Л. Төр-Од “Монгол Улсын Шүүх Эрх Мэдлийн шинэтгэл” судалгааны ажил, 2010; 71 дэх тал.

<sup>2</sup> Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн цахим хуудаснаас авав.

[http://www.judcouncil.mn/index.php?option=com\\_content&view=article&id=314&Itemid=288](http://www.judcouncil.mn/index.php?option=com_content&view=article&id=314&Itemid=288)

<sup>3</sup> Н. Лүндэндорж, Ч. Өнөрбаяр, М. Батсуурь “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” судалгааны ажил, 2010 он; 36 дахь тал.

<sup>4</sup> Монгол Улсын Үндсэн хууль, 1992.

<sup>5</sup> Шүүхийн тухай хууль. 2012.

заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн /шүүхийн захиргааны/ тухай бие даасан хууль анх удаа 2012 онд батлагдсан.

Үндсэн хуульд Шүүх эрх мэдэл засгийн гурван салааны нэгийн хувьд бие даасан байх, шүүгч нь түүний бүрэлдэхүүний хувьд бусдаас хараат бус байхыг онцгойлон зохицуулсан бөгөөд үүний хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл нь төрийн бүх л байгууллага, албан тушаалтан, бусад хүний хөндлөнгийн оролцоо, болзошгүй дарамтаас шүүхийг сэргийлэхэд үйл ажиллагааныхаа голыг чиглүүлэх утгыг агуулж байгааг илэрхийлсэн байна хэмээн МУ-ын Үндсэн Хуулийн эцэг хэмээн хүндлэгдсэн Б. Чимид профессор өөрийн номондоо дурдсан<sup>6</sup> байна.

Шүүхийн захиргааны тухай хууль<sup>7</sup> -аар “Шүүхийн захиргаа нь Ерөнхий зөвлөл, түүний ажлын алба, бүх шатны шүүхийн тамгын газар, судалгааны төв болон бусад туслах нэгжээс бүрдэнэ. Шүүхийн захиргаа нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд арга зүй, мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй байна”<sup>8</sup>. хэмээн заасан байна. Үндсэндээ Шүүхийн захиргааны тухай хууль нь Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс шүүхийн удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилт, материал техникийн хангамж, мэдээллээр үйлчлэх чиг үүрэгтэй байгууллагын статустай болгох үзэл баримтлалыг удирдлага болгон батлагдсан байна.

#### *Шүүхийн Захиргааны Монгол Улс дахь Загвар*

Шүүхийн захиргааны хувьд шүүхийн өөрийн захиргаа /judicial self-management/ гүйцэтгэх эрх мэдлийн захиргаа /executive model/ гэсэн хоёр үндсэн загварыг ардчилсан улсуудад хэрэглэж байна. Шүүхийн өөрийн захиргааны загварыг хэрэгжүүлдэг улс орнуудад шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг Засгийн газар болон шүүхээс өөрөөс нь хараат бус бие даасан байгууллага хэрэгжүүлдэг онцлогтой. Эл загвар ардчиллыг шинээр болон сэргээн тогтоож байгаа улс орнуудын нийтлэг хандлага болоод байна<sup>9</sup>.

Дээрх загвараас гадна Шүүхийн захиргааны байгууллагын талаар судлаачид өөр өөрийн гэсэн загвар гаргасан байх бөгөөд Тарта Их Сургуулийн профессор Jaan Ginter шүүхийн захиргааны загварыг:

1. Гүйцэтгэх байгууллагын загвар,
2. Гүйцэтгэх болон шүүхийн хамтарсан загвар,
3. Шүүхийн загвар,
4. Чиг үүргээ хуваах загвар,
5. Тусгай бие даасан байгууллагын загвар<sup>10</sup>.

хэмээн хуваасан байдаг бол Мөн Nuno Garoupa болон Tom Ginsburg нар 2009 онд Беркелийн Их Сургуулийн Олон Улсын Эрх Зүйн Сэтгүүлд хэвлүүлсэн “The

<sup>6</sup> Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. Хоёрдугаар дэвтэр, УБ, 2004 он, 143 дахь тал.

<sup>7</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл. 2012.

<sup>8</sup> Шүүхийн Захиргааны тухай хууль, 2012 он; 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг.

<sup>9</sup> Н. Лүндэндорж, Ч. Өнөрбаяр, М. Батсуурь “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” судалгааны ажил, 2010 он; 37 дахь тал.

<sup>10</sup> Jaan Ginter, Professor of Criminology of University of Tartu “Judicial Independence and/or Efficient Judicial Administration” илтгэл, 2010.

Comparative Law and Economics of Judicial Councils”<sup>11</sup> нийтлэлдээ Нийтийн Эрх Зүйн бүлийн болон Иргэний Эрх Зүйн бүлийн улсуудын шүүхийн зөвлөлийн харьцуулсан судалгааг хийж Иргэний эрх зүйн бүл бүхий улсуудын шүүхийн зөвлөлийн гол загварыг дэлхийн 2 дугаар дайны дараа буюу 1946 онд байгуулагдсан Францын High Council of the Judiciary (*Conseil Supérieur de la Magistrature*/ -ийн загвар хэмээн дурдсан бөгөөд энэхүү загвар нь 1958 онд Италийн анхны шүүхийн зөвлөл болох (*Consiglio Superiore della Magistratura*) байгуулахад нөлөөлж, цаашид Испани болон Португал улсуудын Шүүхийн Зөвлөлийн загвар, мөн Латин Америкийн улсууд болон хөгжиж буй орнууд болон пост-коммунист орнуудын /Болгар, Хорват, Словак, Украин, Унгар/ Шүүхийн Зөвлөлийн загвар болон үлдсэн байна.

Мөн Prof. Wim Voermans and Dr Pim Albers нар 2003 онд хэвлүүлсэн “Councils for the Judiciary in EU Countries” хэмээх бүтээлдээ Европын улсуудын шүүхийн захиргааны байгууллагуудын загварыг:

1. Өмнөд Европын Шүүхийн Зөвлөлийн Загвар,
2. Хойд Европын Шүүхийн Зөвлөлийн Загвар <sup>12</sup>

хэмээн ангилсан бөгөөд Өмнөд Европын Шүүхийн захиргааны байгууллагын загварын гол төлөөлөгчдөөр Франц, Итали, Хорват, Чех улсыг дурдсан байна. Энэ загварын гол онцлог нь Шүүхийн захиргааны байгууллага нь зөвхөн шүүгчийн томилгоо болон хариуцлагын л асуудлыг хариуцах зэрэг цөөхөн тооны эрх мэдэлтэй байна.

Харин *Хойд Европын Шүүхийн Зөвлөлийн Загвар*-ын гол төлөөлөгчид нь Швед, Ирланд, Дани зэрэг улсууд бөгөөд эл загварын гол онцлог нь шүүгчийн томилгоо, шүүгчийн хариуцлагын асуудлаас гадна мэдээ, мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалт, хүний нөөц зэрэг шүүхээс үйл ажиллагаагаа хараат бусаар, тасралтгүй явуулахад шаардагдах бүхий л асуудлыг шийдвэрлэх өргөн эрх хэмжээтэй байдаг байна.

“Монгол Улсын хувьд нарийн тооцоо, судалгаанд үндэслэлгүй дээрх өөрийн захиргаа /judicial self-management/ болон гүйцэтгэх эрх мэдлийн захиргаа /executive model/ -ны загварын аль алиныг нь, нарийн харвал өмнөд Европын загварыг богино хугацаанд туршиж амжсан бөгөөд шүүхийн захиргааны оновчтой хувилбарыг тогтоож чадаагүйн улмаас шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах талаарх олон жилийн хичээл зүтгэл тодорхой үр дүнд хүрсэнгүй”<sup>13</sup> хэмээн Н. Лүндэндорж профессор судалгаандаа<sup>14</sup> дурдсан байна. Шүүхийн захиргааг Хууль зүйн сайд толгойлж байсныг төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг зөрчиж байна хэмээн өөрчилж, Шүүхийн Ерөнхий зөвлөлийг Улсын дээд шүүхийн хавсрага болгосон нь шүүхийн захиргаа, шүүн таслах ажиллагаа тусгаар байх Үндсэн хуулийн зарчмыг зөрчсөнөөс гадна ерөнхий шүүгчид захиргааны чиг үүргийг олгосноороо шүүгчдийг түүнээс хараат болгох эрсдэл үүсгэн, байдлыг бүр дордуулсан хэрэг болсон. Тиймээс Шүүхийн өөрийн захиргааны загвартай улс орнуудад шүүхийн захиргааг засаглалын бусад байгууллагын албан тушаалтнуудаар биш харин улс төрийн аливаа нөлөөллөөс ангид шалгуур үзүүлэлтэд үндэслэн ил тод шалгаруулах үйл явцыг ашиглан шүүгчдийн өөрсдийнхөө нь дундаас

<sup>11</sup> Nuno Garoupa, Tom Ginsburg “The Comparative Law and Economics of Judicial Councils, 2009 нийтлэлээс илүү дэлгэрүүлэн харна уу.

<sup>12</sup> Prof. Wim Voermans, Dr Pim Albers “Councils for the Judiciary in EU Countries” нийтлэл, 2003.

<sup>13</sup> Н. Лүндэндорж, Ч. Өнөрбаяр, М. Батсуурь “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” судалгааны ажил, 2010 он; 37 дахь тал.

<sup>14</sup> Н. Лүндэндорж, Ч. Өнөрбаяр, М. Батсуурь “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” судалгааны ажил.



тодруулан бүрдүүлэх хандлага хүчтэй байдгийн<sup>15</sup> дагуу Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг анхан шатны шүүхийн шүүгчдийн болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос нэг, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг хүний нэрийг тус тус санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч томилохоор<sup>16</sup> Шүүхийн Захиргааны хуульд оруулсан нь Монгол Улс хэдий пост-коммунист орон хэдий ч өдгөөгийн сонгон авсан загвар нь *өөрийн захиргаа /judicial self-management/*, түүн дундаа нарийвчлан тодорхойлвол *Шведийн Загвар буюу Хойд Европын Шүүхийн Зөвлөлийн Загвар*-ыг хууль боловсруулахдаа удирдлага болгосон хэмээн үзэж болохоор байна.

## **2. Шүүхийн Захиргааны байгууллагын бие даасан загвар, чиг үүрэг - Пост коммунист улсуудын туршлага**

Энэхүү судалгааны ажилд пост-коммунист орны жишээ болгон Унгар, Болгар, Польш, Словак, Литва, Эстони зэрэг орнуудын шүүхийн захиргааны байгууллагын хууль, дээрх орнуудын туршлагийг харьцуулан судлав. Хичнээн эдгээр улсууд адилхан хувь тавилангаар замнаж, адилхан хөгжиж буй орон ангилалд хамаарах хэдий ч өдгөөгийн хүрсэн хөгжил, шүүхийн тогтолцоо, мөн шүүхийн захиргааны байгууллагын бие даасан загварыг дангаар болон холимог байдлаар өөрсдийн хууль, тогтоомжиндоо хэрэглэсэн нь харилцан адилгүй, өөр өөрийн онцлогтой байх тул нэг хайрцаг, нэг загварт нэгтгэн оруулах боломжгүйн учир тус тусад нь тоймлон бичив.

### **2.1. Унгарын Үндэсний Шүүхийн Зөвлөл /National Judicial Council буюу ҮШЗ/**

2011 оны 11 сарын 28-нд Унгарын Шүүхийн захиргаа, зохион байгуулалтын талаарх хууль буюу АКТ CLXI 2011<sup>17</sup> батлагдсан бөгөөд энэхүү хуулийн дагуу 2012 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс байнгийн ажиллагаа бүхий Унгарын Үндэсний Шүүхийн Зөвлөл үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна<sup>18</sup>.

Унгарын Үндэсний Шүүхийн Зөвлөл нь шүүхийн хараат бус байдлыг хангах үүднээс захиргааны үйл ажиллагааг удирдах чиг үүрэг бүхий төвлөрсөн бие даасан үйл ажиллагаатай /supreme self-governing judicial body/ байгууллага юм. Унгарын ҮШЗ нь Будапешт хотноо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Дээд Шүүхийн Ерөнхийлөгч /President of Curia/ болон шүүхийн байгууллагад тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажилласан зан суртахуун болон мэргэшлийн хувьд шалгуур хангасан, бүсийн давж заалдах шатны шүүхийн 1 шүүгч, бүсийн шүүхийн 5 шүүгч, дүүргийн шүүхийн 7 шүүгч, захиргааны болон хөдөлмөрийн шүүхийн 1 шүүгчээс бүрдсэн нийт 15 гишүүнийг 6 жилийн хугацаатайгаар томилно. Унгарын Үндэсний Шүүхийн Зөвлөлийн нэг онцлог нь Зөвлөлийн даргын үүргийг нэг томилогдсон этгээд эсвэл зөвхөн Дээд шүүхийн

<sup>15</sup> Н. Лүндэндорж, Ч. Өнөрбаяр, М. Батсуурь “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” судалгааны ажил, 2010 он; 37-42 дахь тал.

<sup>16</sup> Шүүхийн Захиргааны тухай хууль, 2012 он; 13 дугаар зүйлийн 13.1 дахь хэсэг.

<sup>17</sup> АКТ CLXI 2011 on the Organisation and Administration of Courts of Hungary; [http://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF\(2012\)007-e](http://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF(2012)007-e).

<sup>18</sup> Hungarian National Judicial Council /BIROSAG/; <http://www.birosag.hu/en/njc/national-judicial-council>.

Ерөнхийлөгч гүйцэтгэх бус гишүүд нь хамгийн өндөр зэрэглэлийн шүүгч гишүүнээс эхлэн 6 сар тутам ээлжлэн гүйцэтгэдэг байна<sup>19</sup>.

2011 оны 11 сарын 28-нд Унгарын Шүүхийн захиргаа, зохион байгуулалтын талаарх хууль буюу АСТ CLXI 2011-ийн 103 дугаар зүйлийн<sup>20</sup> дагуу ҮШЗ нь дараах чиг үүрэгтэй:

*1. Захиргааны үйл ажиллагааг удирдах талаар Үндэсний Шүүхийн Зөвлөлийн бүрэн эрх*

а) Үндэсний Шүүхийн байгууллагын /National Judicial Office/ Ерөнхийлөгчийн зүгээс явуулж буй захиргааны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гарсан алдаа дутагдлыг залруулах арга хэмжээ авах,

б) Үндэсний Шүүхийн байгууллагын Ерөнхийлөгчид шүүхтэй холбоотой үйл ажиллагаанд нь зөвлөгөө өгөх,

с) Үндэсний Шүүхийн байгууллагын Ерөнхийлөгчөөс батлан гаргасан дүрэм журам, зөвлөгөөг хянаж, санал өгөх,

*2. Төсвийн талаар Үндэсний Шүүхийн Зөвлөлийн бүрэн эрх*

а) шүүхийн төсвийн зарцуулалтын талаар санал өгч, төсвийн зарцуулалтын талаар мэдээлэх,

б) шүүхийн санхүү эдийн засгийн зохион байгуулалт, менежментэд шалгалт хийх,

с) бусад төрлийн туслалцаа, дэмжлэг, санхүүжилт, түүний нөхцөлийн талаар өөрийн саналаа илэрхийлэх,

*3) Хүний нөөцийн талаар Шүүхийн Зөвлөлийн бүрэн эрх*

а) ҮШЗ болон Дээд шүүхийн Ерөнхийлөгчийн зүгээс шүүгч болон шүүхийн тэргүүнүүдийн талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны жилийн тайланг нийтлэх,

б) ҮШЗ болон Дээд шүүхийн Ерөнхийлөгчийн зүгээс өргөн мэдүүлсэний үндсэн дээр Шүүгч, шүүхийн байгууллагын ажилтанд зэрэг дэв олгох, хүндэт цол тэмдэгээр шагнах,

с) Шүүгчийн санхүүгийн болон хөрөнгийн нээлттэй ил тод байдлыг хангах, хяналт шалгалт явуулах,

д) Шүүгчдийн ёс зүйн хорооны Ерөнхийлөгч болон гишүүдийг томилох,

е) Үндэсний Шүүхийн байгууллагын Ерөнхийлөгч болон Дээд Шүүхийн Ерөнхийлөгчөөр томилогдох этгээдийн талаар өөрийн саналаа өгөх,

ф) Бүсийн давж заалдах шатны шүүх, Бүсийн шүүх, Дүүргийн шүүх, Захиргааны болон Хөдөлмөрийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийг томилох тухай шийдвэрийг гаргах,

<sup>19</sup> АСТ CLXI 2011, Section 89(2).

<sup>20</sup> АСТ CLXI 2011, Section 103.

г) Олонхийн санал авч чадаагүй нэр дэвшигчийн талаарх өөрийн саналаа өгөх,

4) *Сургалтын талаар Шүүхийн Зөвлөлийн бүрэн эрх*

а) Шүүгчдэд зориулсан сургалтын нэгдсэн төлөвлөгөө гаргах,

б) Шүүгчдийн сургалтын тогтолцоо бүрдүүлэх, сургалтын талаарх дүрэм, журамд санал өгөх,

5) Бусад

Ерөнхийд нь дүгнэн үзэхэд Унгарын шүүхийн зөвлөл нь шүүхийн хүний нөөц, сургалтанд илүү анхаарал хандуулсан байх бөгөөд шүүхийн захиргаа, шүүхийн төсөв, санхүүгийн асуудалд төдийлэн өргөн эрх хэмжээтэй бус байгууллага байна.

## ***2.2.Польшийн Шүүхийн Үндэсний Зөвлөл /National Council of the Judiciary/***

1980 оны хоёрдугаар хагасаас шүүхийн болон шүүгчийн хараат бус байдлыг хангах талаар бие даасан төрийн байгууллага байгуулах тухай саналууд хүчтэй гарч, тус байгууллагыг байгуулах эсэх тухай асуудлыг шийдвэрлэх дугуй ширээний ярилцлагийг хэд хэдэн удаа хийсэн бөгөөд 1989 оны 04 сарын 07-ны өдөр Польшийн Үндсэн Хуулинд орсон нэмэлтээр Шүүхийн Зөвлөл байгуулах эрх зүйн үндсийг баталсан байна.<sup>21</sup>

1989 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Шүүхийн Үндэсний Зөвлөлийн акт нэртэй анхны хууль батлагдаж тус хуулиар анхны Шүүхийн Зөвлөлийг байгуулсан бөгөөд Шүүхийн Зөвлөлийн загвартаа Итали Францийн загварыг шууд хуулбарлан хэрэглэсэн. 2011 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Шүүхийн Үндэсний Зөвлөлийн актыг шинэчлэн найруулж уг хуулиар Зөвлөлийн бүтэц, үйл ажиллагааны хүрээ, гүйцэтгэх үүргийн талаар дэлгэрүүлж оруулсан байна.

Шүүхийн Үндэсний Зөвлөл нь Дээд Шүүхийн Тэргүүн Ерөнхийлөгч, Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхийлөгч, Польшийн Ерөнхийлөгчөөс томилох 1 хүн, Хууль Зүйн Яамны сайд, Польшийн Парламентийн доод танхимын 4 гишүүн, 2 сенатор, нийтийн шүүхийн 10 шүүгч, Дээд шүүхийн 2 шүүгч, Захиргааны хэргийн шүүхийн 2 шүүгч, Цэргийн шүүхийн 1 шүүгчээс бүрдэх нийт 25 гишүүнийг 4 жилийн хугацаатайгаар ажиллуулна<sup>22</sup>. Польшийн Зөвлөл нь бусад Европын улсуудтайгаа харьцуулвал илүү олон хүчний төлөөллөөс бүрдсэн онцлог загвартай бөгөөд энэ нь шүүхийн асуудалтай холбогдуулан улс төрийн шийдвэр гаргахад нөлөөтэй хэмээн үздэг.

Шүүхийн Үндэсний Зөвлөлийн актын 3 дугаар зүйлийн дагуу<sup>23</sup> Шүүхийн Дээд Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй:

1) Дээд шүүх, нийтийн шүүх, захиргааны хэргийн шүүх болон цэргийн шүүхийн шүүгчээр томилогдох нэр дэвшигчийг судлах,

<sup>21</sup> National Council of the Judiciary – Польшийн Шүүхийн Үндэсний Зөвлөлийн цахим хуудаснаас авав; <http://www.krs.pl/en>.

<sup>22</sup> ACT of 12 May 2011 on the National Council of the Judiciary, Articles 6-11.

<sup>23</sup> ACT of 12 May 2011 on the National Council of the Judiciary, Article 3.



- 2) Дээд шүүх болон бусад шүүхийн шүүгчээр томилогдох гэж буй нэр дэвшигчийг Польшийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх,
- 3) Шүүгчийн мэргэжилийн ёс зүйн зарчмуудыг батлах,
- 4) Шүүхийн ажилтны эрх зүйн байдлын талаар байр сууриа илэрхийлэх,
- 5) Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага, нийтийн алба болон Польшийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн хөтөлбөрт шүүх засаглал, шүүгчтэй холбогдсон асуудлуудад өөрийн байр сууриа илэрхийлэх,
- 6) Шүүх засаглал, шүүгчийн талаарх асуудлыг зохицуулсан хууль тогтоомжийн төсөлд санал өгөх,
- 7) Шүүгчийн шалгалт, тэдний сургалт, сургалтын материал, сургалтын хөтөлбөрт санал өгөх,
- 8) Шүүгчид болон шүүхийн бусад ажилтны мэргэжлийн сургалтын жилийн хөтөлбөрт санал өгөхөөс гадна

дараах нэмэлт чиг үүрэгтэй:

- 1) Шүүгч, шүүхийн хараат бус байдалтай холбоотой хэм хэмжээ тогтоосон акт нь Польшийн Нэгдсэн Улсын Үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар Үндсэн хуулийн шүүхэд мэдүүлэх,
- 2) Шүүгчийн тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг хэлэлцэх,
- 3) Тэтгэвэрт гарсан шүүгч, шүүгчийн албан тушаалдаа эргэн орох талаарх хүсэлтийг шийдвэрлэх,
- 4) Нийтийн шүүхийн болон цэргийн шүүхийн сахилгын хорооны даргыг / Disciplinary Ombudsmen/-ийг томилох,
- 5) Нийтийн болон цэргийн шүүхийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг томилох, огцруулах асуудалд өөрийн байр сууриа илэрхийлэх,
- 6) Ерөнхий Прокурорын албан тушаалд нэр дэвшигчийг танилцуулах,
- 7) Польшийн Үндэсний Шүүхийн Сургуулийн хөтөлбөрийн зөвлөлийн 3 гишүүнийг нэрлэх,
- 8) Польшийн Үндэсний Шүүхийн Сургуулийн Захиралын албан тушаалд дэвшигчийн талаар өөрийн саналаа хүргүүлэх,
- 9) Польшийн Үндэсний Дурсгалын Төвийн /Судалгааны төв/ зөвлөлийн гишүүнд 2 нэр дэвшигчийг санал болгох,

Польшийн Шүүхийн Дээд Зөвлөлийг дүгнэн үзэхэд илүүтэй улс төрийн нөлөөлөл орсон бусад европын орнууд мөн манай оронтой харьцуулвал чиг үүргийн хувьд цөөхөн, нөлөөлөл багатай байгууллага бөгөөд голлон анхаарч буй зүйл нь шүүгчийн болон бусад байгууллагын удирдах албан тушаалтныг томилоход санал өгөх үүрэгтэй төдий байна.

### **2.3. Болгарын Шүүхийн Дээд Зөвлөл /Supreme Judicial Council/**

Болгарын Шүүхийн Дээд Зөвлөл нь 1991 онд Болгарын Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулиар эрх зүйн үндэс нь тодорхойлогдсон бөгөөд анхны Шүүхийн Дээд Зөвлөлийн Акт 1991 оны 07 дугаар сарын 13-ны өдөр батлагдаж, 1994 он хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж, 1994 оноос Шүүхийн шинэ хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж байсан бөгөөд 2004 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Шүүхийн Дээд Зөвлөлийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, хүрээг нарийвчлан тодорхой зохицуулсан Шүүхийн Дээд зөвлөлийн ажлын журам батлагдан 2007 оноос Дээд Зөвлөл нь байнгийн үйл ажиллагаатай байгууллага болон эмхлэн байгуулагдсан.

Дээд Зөвлөлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгож буй одоогийн хууль нь 2012 оны 06 сарын 10-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.<sup>24</sup>

Шүүхийн Дээд зөвлөл нь мэргэжил болон зан суртахууны хувьд шаардлага хангасан нийт 25 гишүүнтэй бөгөөд Дээд Шүүхийн Ерөнхий Дарга, Захиргааны Хэргийн Дээд Шүүхийн Дарга, Ерөнхий Прокурор нар болон Болгарын Үндэсний Ассамблейгаас сонгогдсон 11 гишүүн, шүүхүүдээс сонгогдсон 11 гишүүнтэйгээр 5 жилийн хугацаатайгаар үйл ажиллагаагаа явуулах бөгөөд улиран сонгогдох боломжгүй<sup>25</sup>.

Болгарын Шүүхийн Дээд Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй<sup>26</sup>:

- 1) Төсвийн тухай хуулийн дагуу Хууль зүйн яамнаас санал болгосон Шүүхийн төсөв хэлэлцэх, төсвийн зарцуулалтанд хяналт тавих,
- 2) Дээд Шүүхээс бусад энгийн шүүхүүдийг Хууль зүйн яам, цэргийн шүүхийг Батлан Хамгаалах яамтай зөвшилцөн шүүхийн байршил, тоог тогтоож, шинээр шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах ажлыг зохион байгуулах,
- 3) Бүх шатны шүүхэд ажиллах шүүгч, прокурор, мөрдөн байцагчид болон шүүхийн ажилчдын тоог тогтоох,
- 4) Шүүхийн захиргааны ажилтны тоог тогтоох,
- 5) Хуульд заасны дагуу шүүгч, прокурор, мөрдөн байцаагчийн албан тушаалд ажиллагсадын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах,
- 6) Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий Прокуророос бусад шүүгч прокурор, захиргааны ажилтныг томилох, зэрэг дэв олгох, хасах, шилжүүлэх, халах асуудлыг хариуцах,
- 7) Болгарын Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчид Дээд Шүүхийн шүүгч, Ерөнхий Прокурорыг томилох болон халах талаар өөрийн санал хүргүүлэх,
- 8) Үндэсний Мөрдөн Байцаах албаны дарга болон Ерөнхий Прокурорын орлогчийг сонгох болон эргүүлэн татах,
- 9) Шүүгч, прокурор, мөрдөн байцаагчийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох,

<sup>24</sup> Supreme Judicial Council of Bulgaria – Болгарын Шүүхийн Дээд Зөвлөлийн цахим хуудаснаас авав. <http://www.vss.justice.bg/en/start.htm>.

<sup>25</sup> Bulgarian REGULATION on the Organization of the Work of the Supreme Judicial Council and its Administration; Article 3.

<sup>26</sup> Bulgarian REGULATION on the Organization of the Work of the Supreme Judicial Council and its Administration; Chapter 2, Section 1, Article 6.

- 10) Шүүх засаглалын байгууллагуудын үйл ажиллагааны жил бүрийн мэдээ, тайланг хэвлүүлэх,
- 11) Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, захиргааны тэргүүн, түүний орлогчийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх,
- 12) Шүүгч, прокурор, мөрдөн байцаагчдын хувийн хэргийг хадгалах, хүний нөөцийн сан бүрдүүлэх,
- 13) Шүүхийн байгууллагын ажилчдын үйл ажиллагаандаа мөрдөх дотоод журмыг батлах,
- 14) 6 сар тутам Шүүх, Прокурор, Мөрдөн байцаах албаны үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэн гаргах,
- 15) Жил бүрийн 05 дугаар сарын 31-ий өдөр гэхэд Дээд Шүүхүүд, Прокурорын газар, Мөрдөн байцаах албаны үйл ажиллагааны жилийн тайланг Үндэсний Ассамблейд хүргүүлэх,
- 16) Шүүхийн шийдвэрийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх,
- 17) Мэдээллийн цахим санг ашиглах зөвшөөрөл олгох, мэдээллийн тогтолцоо, аюулгүй байдлыг сайжруулах, улсын нэгдсэн сүлжээнд хэрхэн холбож ажилуулах зэрэг мэдээллийн технологи, бааз суурьтай холбоотой асуудлыг шийдвэрлэх,
- 18) Шүүгч, прокурор, мөрдөн байцаагчдыг Үндэсний Шүүхийн нэгдсэн сүлжээ, олон улсыг хуулийн байгууллагуудын холбоонд элсэхэд хяналт тавих, удирдан зохион байгуулах,
- 19) Шүүхийн Дээд Зөвлөлийн жилийн үйл ажиллагааны хөтөлбөр болон шалгалтын үйл ажиллагааг гүйцэтгэж буй албан тушаалтанд өөрийн саналаа илэрхийлэх,
- 20) Шүүхийн Дээд Зөвлөлийн актын 230 дугаар зүйлд заасны дагуу шүүгч, прокурор, мөрдөн байцаагчдын үүргээ гүйцэтгэхийг түр түдгэлзүүлэх,
- 21) Шүүгч, прокурор, мөрдөн байцаагчдыг одон медалиар шагнах, давуу эрх олгох талаар Ерөнхийлөгчид уламжлах,
- 22) Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнд шүүгч, прокурор, мөрдөн байцаагчдыг орон тооны багшаар ажиллуулах асуудлыг зохион байгуулах,
- 23) Шүүгч, прокурорын туслахын түвшин, ажлын ачааллыг тохируулах,
- 24) Шүүх засаглалын байгууллагуудын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө, хэтийн зорилтыг тодорхойлох, батлах,
- 25) Шүүхийн болон гэмт хэргийн талаарх статистик судалгаа, мэдээлэл гаргах,
- 26) Олон улсын шүүхийн ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах ,
- 27) Ёс зүйн шаардлагыг зөрчсөн шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, захиргааны тэргүүн, ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах, захиргааны байгууллагын

тэргүүний ногдуулсан буруушаах, сануулах арга хэмжээг батлах, нэмэгдүүлэх, цуцлах,

- 28) Шүүхийн захиргааны ажилтны цалин хөлс, албан тушаал, шаардлага зэргийг тогтоох,
- 29) Дотоод хяналтын хэрэгжилтийн дүрэм, журмыг батлах,
- 30) Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнгийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах,
- 31) Шүүх засаглалын байгууллагын төсөвт хяналт тавих, болон
- 32) Үндэсний Ассамблей болон Засгийн газарт шүүх засаглалын байгууллагуудтай холбоотой хуулийн төсөлд санал өгөх.

Болгарын Шүүхийн Дээд Зөвлөл нь дараах хороотой<sup>27</sup>:

- Шүүгч, Прокурор, Мөрдөн байцаагчдын үнэлгээний хороо,
- Төсөв санхүүгийн хороо,
- Эрх зүйн хороо,
- Ёс зүйн хороо,
- Шүүхийн захиргааны удирдлагын хороо,
- Мэргэжлийн шалгалт, мэдээллийн технологи, статистикийн хороо,
- Сахилгын хороо,
- Гадаад харилцааны хороо,
- Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх хороо,
- Шүүхийн судалгааны хороо,
- Олон нийттэй харилцах хороо гэсэн нийт 11 хороотойгоор үйл ажиллагаа явуулдаг.

Болгар улсын хувьд Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь манай улстай нилээн төстэй бөгөөд бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны цар хүрээ, бүрэлдэхүүний хувьд авч үзэхэд нүсэр бүтэц бүхий байгууллага бөгөөд зөвхөн шүүх гэлтгүй шүүх засаглалын бүхий л байгууллага болон Прокурор, Мөрдөн байцаах алба, Судалгааны үндэсний хүрээлэнг өөртөө зангидсан байна. Чиг үүргийнх хувьд авч үзэж дүгнэлт гаргахад Болгарын Шүүхийн Дээд Зөвлөл нь хүний нөөц, түүний сургалт, мэргэшүүлэх тал дээр өргөн эрхтэй байна.

#### **2.4.Словак Улсын Шүүхийн Зөвлөл /Judicial Council/**

1997 оны Европын комиссын болон Словак улсын Дотоод Явдлын Яамны тайланд Словак улсын шүүхийн тогтолцоонд гүйцэтгэх эрх мэдлээс өөр шүүхийн өөрийн захиргааны байгууллага байхгүй талаар дурдсаны үр дүнд Словак улсын Үндсэн Хуулинд нэмэлт оруулж, тус нэмэлтээр төрийн бусад байгууллагаас хараат бус бие даасан шүүхийн захиргааны байгууллага байгуулах эрх зүйн үндсийг тодорхойлсон байна. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үр дүнд байгуулагдсан Шүүхийн өөрийн

---

<sup>27</sup> Bulgarian REGULATION on the Organization of the Work of the Supreme Judicial Council and its Administration;

захиргааны байгууллага нь шүүхүүдийн менежмент, захиргаа, шүүгчдийг томилох, шилжүүлэх, эргүүлэн татах зэрэг эрх хэмжээтэй болсон.

Өдгөө үйл ажиллагаа явуулж буй Словак Улсын Шүүхийн Зөвлөл нь 2002 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр батлагдсан Словакын Бүгд Найрамдах Улсын Шүүхийн Зөвлөлийн актын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна<sup>28</sup>.

Шүүхийн зөвлөл нь Братислава хотноо Словакын Үндэсний Зөвлөл */the judicial self-governance bodies/*, Словакын Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогдсон нийт 18 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Словак Улсын Дээд Шүүхийн Ерөнхийлөгч нь Шүүхийн Зөвлөлийн дарга байна.

Шүүхийн Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй<sup>29</sup>:

- 1) Шүүгчээр томилогдох нэр дэвшигчийг Словак улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх, мөн шүүгчийн албан тушаалаас эргүүлэн татагдах шүүгчийг танилцуулах,
- 2) Шүүгчдийг шилжүүлэх эсвэл орлон томилох асуудлыг шийдэх,
- 3) Дээд шүүхийн Ерөнхийлөгч, түүний орлогчийг томилох, албан тушаалаас нь буулгах талаар Словак улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх,
- 4) Шүүгчдийн олон улсын байгууллагад Словак улсыг төлөөлөн ажиллах нэр дэвшигчийг Засгийн газарт өргөн мэдүүлэх,
- 5) Ёс зүй, сахилгын хорооны дарга, гишүүдийг сонгох, эргүүлэн татах,
- 6) Улсын төсвийг хэлэлцэх үеэр шүүхийн төсвийн талаар өөрийн байр сууриа илэрхийлэх<sup>30</sup>,
- 7) Шүүхийн төсвийн зарцуулалтын тайланг хэлэлцэх,
- 8) Шүүхийн зөвлөлийн үйл ажиллагааны болон дотоод журам дүрмийг батлах,
- 9) Шүүхийн зөвлөлийн Ерөнхийлөгчийн орлогчийг сонгох,
- 10) Шүүгчийн эрх зүйн байдал, шүүхээс өмнөх шат, шүүх засаглалын байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг хууль, журманд санал өгөх,
- 11) Шүүх засаглалын байгууллагатай холбоотой үзэл баримтлалын баримт бичгүүдэд өөрийн дүгнэлт, саналыг өгч Үндэсний Зөвлөл болон Засгийн Газарт хүргүүлэх,
- 12) Шүүхийн Академийн зөвлөлийн гишүүдийг сонгох,
- 13) Шүүхийн ёс зүйн дүрмийг батлах,
- 14) Шүүхийн байгууллагын дотоод журмыг батлах, болон

<sup>28</sup> Judicial Council of the Slovak Republic – Бүгд Найрамдах Словак Улсын Шүүхийн Зөвлөлийн цахим хуудаснаас авав. <http://www.sudnarada.gov.sk/home-page/>.

<sup>29</sup> 185/2002 Coll. ACT of 11 April 2002 On the Judicial Council of the Slovak Republic and on amendments of certain Acts, Article 4.

<sup>30</sup> The Constitution of the Slovak Republic.



15) Шүүгчийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг батлах.

Словак Улсын Шүүхийн Зөвлөлийг дүгнэвэл төдийлөн өргөн эрх хэмжээгүй, нөлөөлөл сайн бус байгууллага бөгөөд Шүүхэд нөлөөлөх, шүүхийн захиргааг хариуцан ажиллах гэхээсээ илүү санал, зөвлөмж өгөх, мэдээлэлээр хангах зэргээр л үүрэг нь хязгаарлагдаж байна.

## **2.5. Литва улсын Шүүхийн Зөвлөл / Judicial Council/**

Литва улсын Шүүхийн Зөвлөл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах үүднээс байгуулагдсан шүүхийн өөрөө удирдах байгууллага<sup>31</sup> юм.

Шүүхийн Зөвлөл нь 5 жилийн хугацаатайгаар сонгогдсон, нийт 23 гишүүнтэй бөгөөд Дээд Шүүхийн Тэргүүн, Давж заалдах шүүхийн тэргүүн, Захиргааны хэргийн Дээд Шүүхийн Тэргүүн, мөн Дээд Шүүх, Давж заалдах шатны шүүх болон Захиргааны хэргийн Дээд шүүхээс тус бүр 3 шүүгч, бүс болгоны шүүх, бүх захиргааны хэргийн шүүх, тухайн бүсэд үйл ажиллагаа явуулдаг бүх дүүргийн шүүхээс тус бүр нэг, нэг шүүгч нэр дэвшүүлэн сонгоно<sup>32</sup>.

Шүүхийн Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй<sup>33</sup>:

- 1) Шүүхийн Зөвлөлийн Дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргыг нууц санал хураалтаар сонгох,
- 2) Шүүхийн Зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлах,
- 3) Нэгдсэн улсын Ерөнхийлөгчид шүүгчийн томилгоо, эргүүлэн таталт, тэдгээрийн цалин урамшууллын талаар саналаа хүргүүлэх,
- 4) Нэгдсэн улсын Ерөнхийлөгчид шүүхүүдийн тэргүүн, түүний орлогчийн томилгоо, эргүүлэн таталтын талаар санал өгөх,
- 5) Нэгдсэн улсын Ерөнхийлөгчид шүүхүүдэд ажиллах шүүгчдийн тоог тогтоох, өөрчлөх талаар санал өгөх,
- 6) Хуульчдаас шүүгчийн сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, шалгалтын журмыг боловсруулах,
- 7) Шүүхийн Ёс зүй болон Сахилгын комиссын дарга болон гишүүдийг нууц санал хураалтын үндсэн дээр томилох, хуулийн дагуу эргүүлэн татах, тус комиссын үйл ажиллагааны журмыг батлах, тайланг хүлээн авах,
- 8) Шүүхийн Шагналын хорооны гишүүнийг нууц санал хураалтын үндсэн дээр томилох, хуулийн дагуу эргүүлэн татах, тус хорооны журмыг батлах, тайланг хүлээн авах,
- 9) Шүүгчид сахилгын арга хэмжээ авах,

<sup>31</sup> Judicial Council of Lithuania – Литвийн Шүүхийн Зөвлөлийн цахим хуудаснаас авав. <http://www.teismai.lt/en/judicial-council/about-council/>.

<sup>32</sup> The Regulation of Work of the Judicial Council, 2013, Articles 6-8.

<sup>33</sup> The Regulation of Work of the Judicial Council, 2013, Article 20.



- 10) Шүүгчийн үйл ажиллагаагаа хэрхэн явуулж буй талаар дүгнэлт гаргах хороог гаргах, шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, саналыг авч хэлэлцэх,
- 11) Шүүгчдэд хэрэг хувиарлах журам болон шүүгчийн зөвлөгөөний журмыг батлах,
- 12) Шүүхийн захиргааны үйл ажиллагааны журмыг баталж, шүүхийн захиргаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх,
- 13) Шүүгчдийн сургалтын талаарх журам, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургагч багшид тавигдах шаардлагыг батлах,
- 14) Дүүргийн, бүсийн, бүсийн захиргааны хэргийн шүүхүүдийн загвар, орон тоог батлах,
- 15) Шүүхийн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын төсвийн төслийг баталж, Засгийн газарт өргөн мэдүүлэх,
- 16) Үндэсний Шүүхийн Захиргааны үйл ажиллагааны талаарх тайланг сонсох,
- 17) Жил бүрийн 03 дугаар сарын 31-ээс өмнө өмнөх оны шүүхийн үйл ажиллагааны тайланг Үндэсний Шүүхийн Захиргааны цахим хуудсанд нийтлэх,
- 18) Шүүгчдийн Нэгдсэн хурлыг зарлан хуралдуулах,
- 19) Шүүхийн үйл ажиллагаатай холбоо бүхий бусад асуудлаар захиргаа, шүүхийн бүтцийн талаар Литвийн бусад байгууллагатай хамтран ажиллах,
- 20) Шүүхийн үйл ажиллагаатай холбоо бүхий бусад асуудлаар захиргаа, шүүхийн бүтцийн талаар бусад асуудлаар бусад орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах,
- 21) Шүүхийн Зөвлөлийн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдээ, мэдээлэлийг төрийн байгууллагуудаас авах, болон
- 22) Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Литва улсын хувьд Шүүхийн Зөвлөл нь зохион байгуулалтын хувьд сайн бүтэцтэй, чиг үүргийн хувьд ойлгомжтой бөгөөд шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах үүргийг өөртөө хүлээсэн сайн бүтэцтэй байгууллага. Ерөнхий зохион байгуулалт, эрх хэмжээний хувьд манай улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй нилээн төстэй байгууллага хэмээн үзэж болохоор боловч гол чиг үүргээс нь дүгнэж үзэхэд шүүгчдийн сонгон шалгаруулалт, томилгоо, сахилга, шүүгчдийн сургалтанд ихээхэн анхаарал хандуулж, хүний нөөцийг ихээд анхааран үзэх боловч эдийн засгийн эрх мэдэл сул мэт харагдаж байна.

## **2.6. Эстони улсын Шүүхийн Захиргааны байгууллага /Council for Administration of Courts/**

Эстони улсын дээд шүүхийн захиргаа нь /Council for Administration of Courts/ нь бүх шүүхийн захиргааны ажлыг хариуцдаг байна. Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийг Хуульзүйн яам болон шүүхийн захиргааны зөвлөл хамтран удирдан зохион байгуулдаг. Шүүхүүдийн захиргааны зөвлөл дараах тушаалтнуудаас бүрддэг байна. Үүнд:

Улсын дээд шүүхийн тэргүүн шүүгч, 5 шүүгч, Парламентийн (*Riigikogu*) 2 гишүүн, Өмгөөлөгчдийн холбооны зөвлөлийн томилсон өмгөөлөгч, Нийтийн яллагчдын дарга эсвэл түүний томилсон яллагч, Хуулийн дээд түшмэл, эсвэл түүний томилсон төлөөлөгч, Хуульзүйн сайд эсвэл түүний томилсон төлөөлөгч зэргийг зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулдаг байна.

Зөвлөл нь дараах чиглэлээр дэмжлэг үзүүлнэ:

- 1) Шүүх эрх мэдэл хэрэгжих газар нутгийг тогтоох, шүүхийн бүтэц, зохион байгуулалт, шүүхийн байр болон түүний дугаарлалт, шүүх үйл ажиллагаа явуулах орчноор хангах,
- 2) Шүүхийн даргыг томилох эсвэл хугацаанаас нь өмнө чөлөөлөх,
- 3) Шүүхийн байгууллагын дотоод журмыг тогтоох,
- 4) Шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэх, тодорхойлох,
- 5) Шүүгчдэд онцгой нэмэлт төлбөр, шагнал урамшуулал олгох.

Зөвлөл нь мөн дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

- 1) Шүүхийн жил бүрийн төсвийн засвар, зарцуулалт төлвийн талаар дүгнэн хэлэлцүүлэх,
- 2) Улсын дээд шүүхийн сул орон тоонд шүүгчдийг нэр дэвшүүлж сонгох,
- 3) Шүүгчийг чөлөөлөх арга хэмжээ авах,
- 4) Улсын дээд шүүхийн дарга Парламентад шүүхийн захиргаа болон хууль зүйн захиргааны байдлын тухай хэлэлцүүлэх,
- 4) Хууль зүйн сайд болон дээд шүүхийн даргын санаачлагаар бусад асуудлыг хэлэлцэж болно<sup>34</sup>.

Эстони улсын дээд шүүхийн захиргаа нь зохион байгуулалтын хувьд Улсын дээд шүүхийн тэргүүн, Дээд шүүхийн ажлын алба (*Supreme Court Office*), Бүртгэл тооцооны газар, Боловсон хүчний газар, Эд хөрөнгийн газар, Мэдээллийн технологийн газар, Хуульзүйн мэдээллийн газар, (*Шүүхийн статистик, бусад судалгаа хамаарна*) Олон

<sup>34</sup> Эстони улсын Шүүхийн захиргааны байгууллагын албан ёсны цахим хуудас <http://www.nc.ee/?id=1343>.

нийттэй харилцах газар, Шүүгчдийн сургалтын газар, зөвлөлийн тэргүүнд хуульзүйн зөвлөх газар гэсэн нэгжүүдээс бүрддэг байна<sup>35</sup>.

### **3. Шүүхийн Захиргааны байгууллагын бие даасан загвар, чиг үүрэг - Европын Холбооны болон бусад өндөр хөгжилтэй улсуудын жишээ, загвар**

Nuno Garoupa болон Tom Ginsburg нар 2009 онд Беркелигийн Их Сургуулийн Олон Улсын Эрх Зүйн Сэтгүүлд хэвлүүлсэн "The Comparative Law and Economics of Judicial Councils"<sup>36</sup> нийтлэлдээ Иргэний эрх зүйн бүл бүхий улсуудын шүүхийн зөвлөлийн гол загварыг дэлхийн хоёрдугаар дайны дараа буюу 1946 онд байгуулагдсан Францын High Council of the Judiciary (*Conseil Superieur de la Magistrature*/ -ийн загвар хэмээн дурдсан бол Prof. Wim Voermans and Dr Pim Albers нар 2003 онд хэвлүүлсэн "Councils for the Judiciary in EU Countries" хэмээх бүтээлдээ Европын улсуудын шүүхийн захиргааны байгууллагын загварыг:

- Өмнөд Европын Шүүхийн Зөвлөлийн Загвар,
- Хойд Европын Шүүхийн Зөвлөлийн Загвар<sup>37</sup>

хэмээн ангилсан бөгөөд Өмнөд Европын Шүүхийн Зөвлөлийн загварын гол төлөөлөгчдөөр Франц, Итали, Хорват, Чех улсыг дурдсан байна. Энэ загварын гол шинж нь Шүүхийн Зөвлөл нь зөвхөн шүүгчийн томилгоо болон хариуцлагын л асуудал зэрэг цөөхөн тооны асуудлыг хариуцдаг бол *Хойд Европын Шүүхийн Зөвлөлийн Загварын* гол төлөөлөгчид нь Швед, Ирланд, Дани зэрэг улсуудыг дурдсан байна. Эл загварын гол шинж нь шүүгчийн томилгоо, шүүгчийн хариуцлагын асуудлаас асуудлаас гадна мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалт, хүний нөөц зэрэг шүүхээс үйл ажиллагаагаа хараат бусаар, тасралтгүй явуулахад шаардагдах бүхий л асуудлыг шийдвэрлэх өргөн эрх хэмжээтэй байдаг байна.

#### **3.1.Швед Улсын Шүүхийн Зөвлөл / *Dolmstolsverket***

1974 оны Шведийн Үндсэн Хуулинд */Regeringsform 1974/* шүүх, шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулж, Засгийн Газар, Парламентын зүгээс ямар нэгэн байдлаар шүүхийн хараат бус байдалд хөндлөнгөөс оролцож, хэрэг маргаан шийдвэрлэх үйл ажиллагаанд нөлөөлөх явдлыг хуулиар хориглосон<sup>38</sup>. Шведийн шүүхийн тогтолцоо нь Нидерланд зэрэг ижил төсөө бүхий орноосоо ихээхэн ялгаатай бөгөөд тус гол ялгаа нь шүүхийн захиргааны асуудлыг бие даасан төрийн байгууллага хариуцдаг байна.

1975 оноос шүүхийн хараат бус байдал, шүүхийн захиргаа, менежмент, төсөв, санхүүгийн асуудлыг хариуцсан тусгай зорилго бүхий бие даасан захиргааны байгууллага байгуулагдсан нь Шүүхийн Зөвлөл. Шведийн Шүүхийн Зөвлөл нь Шүүх болон Засгийн газар хооронд гүүр болон оршиж, өөрийн гэсэн тусгай, онцгой үүрэг бүхий байгууллага юм. Шүүхийн Зөвлөл нь Ерөнхий захирал болон 6 шүүгч, 2 Парламентын гишүүн, холбооны 2 төлөөлөгчөөс бүрдсэн нийт 11 гишүүнтэй.

<sup>35</sup> <http://www.nc.ee/?id=1292>.

<sup>36</sup> Nuno Garoupa, Tom Ginsburg "The Comparative Law and Economics of Judicial Councils, 2009 нийтлэлээс илүү дэлгэрүүлэн харна уу.

<sup>37</sup> Prof. Wim Voermans, Dr Pim Albers "Councils for the Judiciary in EU Countries" нийтлэл, 2003.

<sup>38</sup> Sweden Constitution, 1974, Chapter 11, Article 2.

Шүүхийн Зөвлөл нь жил бүр төсвийн тухай хуулийн дагуу шүүхийн төсвийг төлөвлөж, хууль тогтоох байгууллагад өргөн барьж батлуулахаас эхлээд төсөв захиран зарцуулах, түүн дундаа олон төрлийн санхүү, төсөвтэй холбоотой асуудлууд, жишээ нь санхүүгийн аудит, шүүхийн цалин хөлс, үйл ажиллагааны зардал, мэдээллийн бааз, автомашины зардал зэрэг нэмэлт зардал, хангамжууд зэрэг бүх л шүүхийн төсөв, санхүүтэй холбоотой асуудлыг шийдэх өргөн эрх хэмжээтэй байгууллага байна. Мөн Зөвлөл шүүхийн болон шүүгчдийн ахуй хангамжийн талаар ихээхэн анхаарч ажилладаг бөгөөд шүүхийн байр, танхимын тохижолтоос авхуулан бүхий л шүүхтэй холбоотой асуудлуудыг голлон хариуцдаг байна. Шүүхийн Зөвлөл нь мөн шүүхийн ажилтнуудын хүний нөөцийн менежмент, сургалтын асуудалд ихээхэн анхаарал хандуулж, хуульчдын давтан сургалтууд, сургалтын хөтөлбөр, үр нөлөөтэй сургалтуудыг зохион байгуулах талаар ихээхэн анхаарч ажиллаж байна.

Зөвлөлийн Ерөнхий Захирал нь захиргааны асуудлууд дээр голлох шийдвэр гаргахаас гадна төсвийн зарцуулалт, сургалтын хөтөлбөр болон шүүхийг дэмжих үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.<sup>39</sup>

### **3.2. Ирландын Шүүхийн Үйлчилгээний байгууллага /Court Service/**

1922 онд Бүгд Найрамдах Ирланд улс байгуулагдаж, 1922 оны Үндсэн хуулиа батлахаас өмнө Ирландын шүүхийн тогтолцоо, шүүхийн байгууллагын хэлбэр Британийн нөлөө их орсон байсан боловч 1924 онд Ирландын Шүүхийн тухай хууль батлагдаж, Ирландын Хууль Зүйн сайд нь шүүхийн менежментийг хариуцах ажиллах дээд эрх хэмжээтэй этгээд болсон байна.

1995 оноос Бүгд Найрамдах Ирланд Улсын Үндсэн хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 хэсэгт шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулж өгсөн үеэс Ирландын шүүхийн байгууллагуудад томоохон өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн. Эхэндээ шүүхийн тогтолцооны бүхий л асуудлыг Хууль Зүйн Сайд дангаараа хариуцдаг, сайд дангаараа болон кабинетаараа Парламентийн өмнө ажлаа тайлагнадаг байсан хуучин тогтолцоог үр дүн, ач холбогдол багатай хэмээн үзэж тусгай менежментийн асуудлыг хариуцсан бүтцийг байгуулах талаар санаачлага гаргаж, 1996 онд Шведийн загварыг суурь болгон Шведийн Шүүхийн Зөвлөлтэй адилхан чиг үүрэг бүхий Ирландын Шүүхийн Үйлчилгээний Байгууллагыг /Court Service/ 1998 онд албан ёсоор байгуулсан.

Шүүхийн Үйлчилгээний байгууллага байгуулагдахад Хууль зүйн сайд өөрийн эрх хэмжээнд хамаарах зарим менежментийн болон санхүүгийн эрхээ шинээр байгуулагдсан байгууллагад шилжүүлсэн ч зарим эрхээ өөртөө хадгалан үлдсэн. 1998 онд Шүүхийн Үйлчилгээний байгууллагын акт /Court Service Act 1998/ батлагдсан ба тус актад Үйлчилгээний байгууллага нь Ерөнхий захирал, Зөвлөл, ажлын албанаас бүрдэх бөгөөд эрх барих гол байгууллага нь нийт 17 гишүүнээс /9 гишүүн нь шүүхийн байгууллагын төлөөлөгч байна/ бүрдсэн Зөвлөл хэмээн заасан<sup>40</sup>. Зөвлөл нь Байгууллагын бүх эрхийг барих бөгөөд ерөнхий захирал нь зөвлөлийн албан ёсны

<sup>39</sup> Prof. Wim Voermans, Dr Pim Albers “Councils for the Judiciary in EU Countries” харьцуулсан судалгааны бүтээлээс тоймлон оруулав.

<sup>40</sup> Ireland Court Service Act 1998, Article 11.

гишүүн боловч мэдээлэл, тайлан өгөх, төсвийн хувиарлалт, олон нийтэд мэдээлэл өгөх зэрэг үүргүүдийг гүйцэтгэдэг. Мөн Парламентийн өмнө асуулгад хариулахаас гадна байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна<sup>41</sup>.

Шүүхийн үйлчилгээний байгууллага нь дараах чиг үүрэгтэй:

- Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах,
- Олон нийтэд шүүхийн талаар мэдээлэл өгөх,
- Шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах,
- Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах,
- Шүүхээр үйлчлүүлж буй этгээдүүдийг таатай нөхцөл хангах<sup>42</sup>.

Дээрх үүргийг гүйцэтгэх үүднээс шүүх нь үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, ажилчдыг сургах сургалтын хөтөлбөртэй холбоотой гэрээ хэлэлцээр байгуулах, шүүхтэй холбоотой зардал, төлбөрийн талаар Сайдад санал оруулах, шүүхийг үүргээ гүйцэтгэхтэй холбоотой зөвлөх, мэргэжилтнүүдийг авч ажиллуулах, шүүхийн байр, танхимыг тохижуулах зэрэг захиргаа, менежментийн үүргээс гадна шүүхийн төсөв, санхүүгийн төлөвлөгөө гарган Хууль Зүйн сайдаар дамжуулан Парламентаар хэлэлцүүлнэ. Шүүхийн Үйлчилгээний байгууллага нь сайдын нэгдсэн бодлоготой уялдуулан 3 жил тутам стратегийн төлөвлөгөө гаргана. Мөн шүүхийн менежмент, шүүхийн санхүүгийн хяналт, хүний нөөцийн менежментийн асуудлуудыг хариуцан ажилладаг боловч шүүхийн ажилтан, шүүгчийн томилгоог хийдэггүй бөгөөд шүүгчдийн сургалт, карьерийн хөгжилд анхаарлаа хандуулан ажилладаг. Ерөнхийдөө Шүүхийн Үйлчилгээний байгууллага нь шүүхийн байгууллагыг илүү үр нөлөөтэй, үр дүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулахад зориулан санхүү, захиргаа, хүний нөөц зэрэг бүх талаас нь үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаж байна.

### **3.3. Дани Улсын Шүүхийн Захиргааны байгууллага /Domstolsstyrelsen/**

1953 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Данийн Үндсэн хуулийн<sup>43</sup> 62 дугаар зүйлд Шүүхийн захиргаа нь Гүйцэтгэх байгууллагын эрх хэмжээнд хамаарна хэмээн заасан хэдий ч Дани улс Шүүхийн бие даасан зөвлөл байгуулсан. Данийн Шүүхийн Зөвлөл нь Европын улсууд дундаа хамгийн сүүлд байгуулагдсан зөвлөл бөгөөд ерөнхийдөө Ирландын Шүүхийн Үйлчилгээний байгууллагатай төстэй боловч Шведийн Шүүхийн Зөвлөлөөс зарим нэг зүйлсийг авсан байна.

Данийн Шүүхийн захиргааны байгууллага нь 1999 оны 07 дугаар сарын 1-ны өдөр албан ёсоор бие даасан байгууллага болон байгуулагдсан. Шүүхийн захиргаа нь 8

<sup>41</sup> Ирландын шүүхийн үйлчилгээний байгууллагын албан ёсны цахим хуудас.  
<http://www.courts.ie/courts.ie/library3.nsf/pagecurrent/39EE41AE3259894B80256DA90036F8BD?op=endocument&l=en>.

<sup>42</sup> Ireland Court Service Act 1998, Article 5.

<sup>43</sup> The Constitutional Act of Denmark of June 5, 1953.



шүүхийн төлөөлөгч, 1 хуульч, 2 тусгай менежмент, нийгмийн чиглэлээр мэргэшсэн 2 хүн, нийт 11 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулна<sup>44</sup>.

Захиргааны байгууллагыг Зөвлөл болон захирал удирдана. Данийн Шүүхийн захиргааны байгууллага нь Хууль зүйн яамны удирдлага дор байх боловч Хууль зүйн сайд нь Захиргааны байгууллагын шийдвэрт нөлөөлөх, түүнийг өөрчлөх эрх хэмжээгүй. Зөвлөлийн ерөнхий зөвлөл нь зөвлөлийн ерөнхий бодлогыг тодорхойлох үүрэгтэй. Хамгийн гол үүргийн нэг нь төсөв, санхүүтэй холбоотой үүрэг бөгөөд Зөвлөл төсвийн хуулийн дагуу төсвийн зарцуулалт, хувиарлалт, хяналтанд онцгой анхаарал хандуулдаг. Мөн төсөв, санхүүгийн эрхээс гадна Зөвлөлийн өөр анхаарал хандуулах зүйл нь шүүхийн байгууллагуудын менежмент, бүх төрлийн менежмент, сургалт, хүний нөөц, байр сав, зөвлөгөө мэдээлэл, сурталчилгаа зэрэг асуудлыг мөн хамаарна. Шүүхийн Захиргааны байгууллагын Захирал Зөвлөлөөс томилогдох бөгөөд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна Зөвлөлөөс даалгасан ажлыг гүйцэтгэнэ. Захиралыг заавал хуульч байхыг шаарддаггүй.

Урьд шүүгч ганцхан туслагчтай байсан бол одоо бүхэл бүтэн захиргааны байгууллага эл үүргийг хариуцан ажиллах болсон нь их үр нөлөөтэй болсон. Данийн шүүхийн захиргааны байгууллага нь Менежментийн гол үүргээс гадна, шүүгчийн сонгон шалгаруулалт, сайдад томилгооны асуудал дээр зөвлөгөө өгөх эрх хэмжээтэй байна.

### **3.4. Америкийн Нэгдсэн Улсын шүүхийн захиргааны байгууллага / Administrative Office of the United States Courts/**

Америкийн Нэгдсэн Улсын шүүхийн захиргааны байгууллага нь 1939 онд байгуулагдсан бөгөөд Үндсэн хуулийн дагуу холбооны шүүхийн хараат бус, шударга ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлдэг. АНУ-ын Шүүхийн захиргааны байгууллага нь гүйцэтгэх засаглал ч бус, шүүх засаглал ч бус өвөрмөц онцлог бүхий төрийн байгууллага боловч шүүх засаглалын захиргааны үүргийг хариуцсан өргөн эрх мэдэлтэй байгууллага. Тус байгууллага нь шүүхийн нэрийн өмнөөс Гүйцэтгэх засаглал болон Конгресстэй харилцдаг байна<sup>45</sup>. АНУ нь холбооны шүүхийн тогтолцоотой тул муж улс бүр шүүхийн захиргааны байгууллагатай.

Эдгээр байгууллага нь шүүхийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, шүүхийн төсөв төсөвлөх, шүүхийн байр, боловсон хүчнийг бүрдүүлэх, хурал зохион байгуулах, олон нийтийн мэдээллийн асуудлыг хариуцах, сургалт, судалгаа явуулах, мэдээллийн технологийг хариуцах зэрэг үүрэг гүйцэтгэдэг байна. Шүүхийн захиргааны байгууллагын даргыг шүүгчдийн хурлаар томилдог бөгөөд тус байгууллага нь Захирал, Дэд захирал, Ерөнхий зөвлөл, Шүүгчдийн хурлын гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Хууль тогтоох алба, Олон нийттэй харилцах алба, Өмгөөллийн алба, Хүний

---

<sup>44</sup> Дани улсийн Шүүхийн Зөвлөл /Domstolsstyrelsen/-ийн албан ёсны цахим хуудаснаас авав. <http://www.domstol.dk/om/otherlanguages/english/thedanishjudicialsystem/courtadministration/Pages/default.aspx>.

<sup>45</sup> АНУ-ын Шүүхийн захиргааны байгууллагын албан ёсны цахим хуудас- <http://www.uscourts.gov/FederalCourts/UnderstandingtheFederalCourts/AdministrativeOffice.aspx>.



нөөцийн алба, Төсөв, санхүүгийн алба, Аюулгүй байдал, хамгаалалтын алба, Батлан даалт болон зөвлөгөөний алба, Мэдээллийн технологийн алба зэрэг нэгжүүдээс бүрддэг байна<sup>46</sup>.

### **3.5. Канад улсын шүүхийн захиргааны байгууллага /Courts Administration Service/**

Канадын шүүхийн захиргааны байгууллага нь 2003 онд байгуулагдсан. Канадын “Шүүхийн захиргааны албаны тухай” актыг үйл ажиллагаандаа мөрддөг. Тус байгууллагын гүйцэтгэх гол үүрэг нь Холбооны давж заалдах шүүх, давж заалдах шүүх, цэргийн давж заалдах шүүх, татварын шүүх зэрэг дөрвөн шүүхийн үйл ажиллагааг зохион байгуулах юм. Шүүхийн захиргааны тухай хууль нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Канадын давж заалдах шатны шүүх, холбооны шүүх, цэргийн давж заалдах шатны шүүх, татварын шүүх зэрэг байгууллагын хоорондын уялдаа холбоо, ажлыг хөнгөвчлөх, дэмжлэг үзүүлэх,
- Шүүхийн бие даасан, засгийн газраас хараат бус байдлыг нэмэгдүүлж, шүүхийн зохион байгуулалт, менежментийн асуудлыг хариуцах,
- Шүүх нь санхүүгийн хувьд хараат бус бие даасан байдлыг бий болгох, санхүү, мөнгөтэй холбоотой асуудлаар олон нийтэд тайлагнах ажлыг шүүхийн захиргаанаас гүйцэтгэх зэрэг юм<sup>47</sup>.

Шүүхийн захиргааны даргыг таван жилийн хугацаатай томилдог бөгөөд түүнийг тухайн мужийн захирагч томилдог байна. Хуульзүйн сайд Канадын давж заалдах, холбооны, цэргийн давж заалдах шатны болон татварын шүүхийн дарга нарт зөвлөгөө өгөх үүрэгтэй бөгөөд тус шүүхийн удирдлагыг дахин томилох эсэхийг шийдвэрлэх эрхтэй байдаг байна.<sup>48</sup>

---

<sup>46</sup><http://www.uscourts.gov/FederalCourts/UnderstandingtheFederalCourts/AdministrativeOffice/DirectorAnnualReport/annual-report-2012/in-profile.aspx>.

<sup>47</sup>Канад улсын Шүүхийн захиргааны байгууллагын албан ёсны цахим хуудас-  
[http://cas-ncr-nter03.cas-satj.gc.ca/portal/page/portal/CAS/mandate-mandat\\_eng](http://cas-ncr-nter03.cas-satj.gc.ca/portal/page/portal/CAS/mandate-mandat_eng)

<sup>48</sup> <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/C-45.5/page-1.html#h-3>.

#### **4.Дүгнэлт**

Нийтдээ 6 пост-коммунист улс, 3 Европын Холбооны өндөр хөгжилтэй улс, АНУ болон Канад зэрэг улсуудын шүүхийн бие даасан загвар бүхий захиргааны байгууллагуудыг харьцуулан судлав. Судалгаанаас дүгнэн үзэхэд дээрх улсууд захиргааны байгууллагын бие даасан загварыг /judicial self-management/авсан гэж хэлж болохуйц боловч ихээхэн холимог, өөр өөрийн гэсэн онцлог бүхий загварыг бий болгосон байна.

Болгар болон Литва улс нь манай улстой ойролцоо загвар бүхий шүүхийн захиргааны байгууллагатай боловч нарийвчлан авч үзэхэд зарчмын гэмээр томоохон ялгаа ажиглагдаж байна. Болгар улсын хувьд Шүүхийн Зөвлөл нь зөвхөн шүүхийн байгууллагаас гадна Прокурор, Мөрдөн байцаах албаны захиргааны асуудлыг бүхэлд нь цогцоор хамран үйл ажиллагаагаа явуулдаг бүхэл бүтэн нүсэр тогтолцоотой бол Литва улсын хувьд манай улстай төстэй боловч Зөвлөлийн гишүүнд Дээд шүүхийн тэргүүн, Давж заалдах шүүхийн тэргүүн, Захиргааны хэргийн давж заалдах шүүхийн тэргүүн нь албан тушаалын байдлаараа шууд орсон нь манай өмнөх загвартай ихээхэн адилхан мэт, гэхдээ хэрэгжүүлж буй чиг үүргийнхээ хувьд одоогийн тогтолцоотой тун төсөөтэй байна.

Бусад пост-коммунист улсуудын хувьд шүүхийн захиргааны байгууллагууд нь чиг үүргийн хувьд бага, төдийлөн өргөн эрх хэмжээтэй бус, үйл ажиллагаа нь сул гэмээр, шүүх засаглалаа улс төрийн хүчнээс тусгаарлаж, засаглал хуваах зарчмыг хэрэгжүүлж чадаагүй байна.

Харин өндөр хөгжил бүхий Европын улсууд болон АНУ, Канад зэрэг улсуудын хувьд шүүхийн захиргааны байгууллага нь удаан жилийн түүхтэй, нэгдсэн нэг загвар дээр үндэслэн байгуулагдсан мэт боловч өөр өөрийн гэсэн онцлогийг сайн тусгасан байна.

Дээрх улсуудын туршлагаас харахад манай улсын шүүхийн захиргааны хууль өөрийн онцлогтой, бусадтай жиших боломжгүй байна. Гэхдээ бусад улсын туршлагаас харахад манай улсын хуулинд тусгагдаагүй хоёр зүйл байгаа нь, нэгт, Болгар улсын Шүүхийн Зөвлөлийн шүүхийн байгууллагаас гадна Прокурор, Мөрдөн байцаах албаны захиргааны асуудлыг цогц байдлаар хамран үйл ажиллагаа явуулдаг нүсэр тогтолцоо, хоёрт, Хойд Европын улсуудад нийтлэг ажиглагдах Шүүхийн захиргааны байгууллагийн дотоод бүтэц буюу Зөвлөл /Board/-ийн тогтолцоо байна. Эдгээр тогтолцоо, онцлогийг нарийн судалж, өөрийн орны хууль тогтоомжинд тусгаж болох эсэх болон хэрэгжүүлж болох эсэх талаар судалгаа хийхээс гадна мөн бусад улсын шүүхийн захиргааны байгууллагын чиг үүргүүдээс манай улсад авч хэрэгжүүлэхүйц ямар чиг үүрэг байж болох, түүний практик дээр хэрэгжих байдлын талаар улс орон бүрээр нь нарийвчилсан судалгаа цаашид хийх нь зүйтэй.

## **5.Эх сурвалж**

### **1.Хууль, тогтоомж, олон улсын гэрээ, эрх зүйн баримт бичиг**

#### **- Монгол Улсын хууль тогтоомж**

1. Монгол Улсын Үндсэн Хууль. 1992
2. Монгол Улсын шүүхийн тухай хууль. 2012
3. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2012
4. Шүүхийн захиргааны тухай хууль. 2012
5. Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөж журмын тухай хууль. 2012

#### **- Гадаад улсын хууль, тогтоомж**

1. Швед улсын Үндсэн Хууль. 1974
2. Словак улсын Үндсэн Хууль.
3. Дани улсын Үндсэн Хууль. 1953
4. Унгар улсын шүүхийн Захиргаа зохион байгуулалтын хууль. 2012
5. Польш улсын Шүүхийн Үндэсний Зөвлөлийн Акт. 2011
6. Болгар улсын Шүүхийн Дээд Зөвлөлийн хууль. 2009
7. Словак улсын Шүүхийн Зөвлөлийн акт. 2002
8. Литва улсын Шүүхийн Зөвлөлийн хууль. 2013
9. Ирланд улсын шүүхийн үйлчилгээний байгууллагын акт. 1998

### **2.Судалгаа, тайлан, эмхтгэл**

#### **- Монгол хэл дээр**

1. Ж. Амарсанаа, Б. Чимид, Р. Мухийт, Л. Төр-Од “Монгол Улсын Шүүх Эрх Мэдлийн шинэтгэл” судалгааны ажил. 2010
2. Б.Буяндэлгэр, Ш.Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа “Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд” судалгаа. 2009
3. Н. Лүндэндорж, Ч. Өнөрбаяр, М. Батсуурь “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” судалгааны ажил. 2010

#### **- Гадаад хэл дээр**

1. Jaan Ginter, Professor of Criminology of University of Tartu “Judicial Independence and/or Efficient Judicial Administration” илтгэл. 2010
2. Garoupa, Tom Ginsburg “The Comparative Law and Economics of Judicial Councils. 2009
3. Prof. Wim Voermans, Dr Pim Albers “Councils for the Judiciary in EU Countries”. 2009

### 3. Ном, бусад эх сурвалж

#### - Монгол хэл дээр

1. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. Хоёрдугаар дэвтэр, УБ, 2004 он

### 4. Цахим эх сурвалжууд

#### - Монгол хэл дээр

- 1 МУ-ын Шүүхийн Үндэсний Зөвлөл - [www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn)

#### - Гадаад хэл дээр

1. Болгарын Шүүхийн Дээд Зөвлөл - <http://www.vss.justice.bg/en/start.htm>
2. Бүгд Найрамдах Словак Улсын Шүүхийн Зөвлөл - <http://www.sudnarada.gov.sk/home-page/>
3. Ирландын шүүхийн үйлчилгээний байгууллага <http://www.courts.ie/courts.ie/library3.nsf/pagecurrent/39EE41AE3259894B80256DA90036F8BD?opendocument&l=en>
4. Дани улсын Шүүхийн Зөвлөл /Domstolsstyrelsen/- <http://www.domstol.dk/om/otherlanguages/english/thedanishjudicialsystem/courtadministration/Pages/default.aspx>
5. Литвийн Шүүхийн Зөвлөл - <http://www.teismai.lt/en/judicial-council/about-council/>
6. Унгар улсын Үндэсний Шүүхийн Зөвлөл /BIROSAG/- <http://www.birosag.hu/en/njc/national-judicial-council>
7. Польшийн Шүүхийн Үндэсний Зөвлөл - <http://www.krs.pl/en>
8. АНУ-ын Шүүхийн захиргааны байгууллагын албан ёсны цахим хуудас- <http://www.uscourts.gov/FederalCourts/UnderstandingtheFederalCourts/AdministrativeOffice.aspx>
9. Канад улсын Шүүхийн захиргааны байгууллагын албан ёсны цахим хуудас- [http://cas-ncr-nter03.cas-satj.gc.ca/portal/page/portal/CAS/mandate-mandat\\_eng](http://cas-ncr-nter03.cas-satj.gc.ca/portal/page/portal/CAS/mandate-mandat_eng)

### 6. Хавсралт

	Монгол Улсын ШЗБ-тай ижил чиг үүрэг	Монгол Улсын ШЗБ-аас ялгаатай чиг үүрэг	Давуу тал	Сул тал
1. Унгарын Үндэсний Шүүхийн Зөвлөл	<p>а) Шүүхийн төсвийн зарцуулалтын талаар санал өгч, төсвийн гүйцэтгэлийн талаар мэдээлэх, шүүхийн санхүү, эдийн засаг, бүртгэлийг хянан шалгах,</p> <p>б) Шүүгч, шүүхийн байгууллагын ажилтанд зэрэг дэв олгох, хүндэт цол тэмдэгээр шагнах,</p> <p>с) Нэгдсэн сургалтын төлөвлөгөө гаргахад туслах, Шүүгчдийн сургалтын тогтолцоо бүрдүүлэх болох суралцах үүргийн талаарх дүрэм журамд санал өгөх,</p> <p>д) Шүүгчдийн сахилгын зөвлөлийн гишүүн болон Ерөнхийлөгчийг томилох,</p> <p>е) Шүүгчээр томилогдох этгээдийн талаар этгээдийн талаар дүгнэлт гаргах,</p>	<p>а) Үндэсний Шүүхийн байгууллагын /National Judicial Office/ Ерөнхийлөгчийн зүгээс явуулж буй захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөгөө өгөх.</p>	Илт онцлог давуу тал байхгүй.	<p>Эрх хэмжээний хувьд манай улсын шүүхийн захиргааны байгууллагаас хумигдмал байна.</p> <p>Мөн Дээд Шүүхийн Ерөнхийлөгч албан тушаалын байдлаараа шүүхийн захиргааны байгууллагад ордог явдал нь манай улсын өмнөх загвартай бага зэргийн төстэй байна.</p>
2. Польшийн Үндэсний Шүүхийн Зөвлөл	<p>а) Шүүгчээр томилогдох этгээдийг судлах, ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх,</p> <p>б) Шүүхийн ажилтнуудын эрх зүйн байдлыг тогтоох,</p> <p>с) Шүүгчийн сургалтыг хариуцах,</p> <p>д) Ес зүйн хорооны тэргүүнийг томилох,</p> <p>е) Шүүгчийн эрх зүйн байдалтай холбоотой хууль, тогтоомжинд санал өгөх, Үндсэн хуульд нийцэж буй эсэхэд анхаарал хандуулах.</p>	<p>а) Шүүгчийн тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг хэлэлцэх,</p> <p>б) Прокурорын албан тушаалд нэр дэвшигчийг танилцуулах,</p> <p>с) Шүүхийн сургуулийн захиралын албан тушаалд дэвшигчийн талаар санал өгөх.</p>	Илт онцлог давуу тал байхгүй.	Олон хүчний төлөөлөлөөс шүүхийн захиргааны байгууллагаа бүрдүүлсэн нь шүүх засаглалын бие даасан байдал, төрийн эрх мэдлийг хувирлах онолтой зөрчилдөж байна.





7. Швед улсын Шүүхийн зөвлөл	Ихэнх чиг үүрэг нь адилхан	Санхүүгийн аудит хийх эрх	Эл тогтолцоогоор удаан жил үйл ажиллагаа явуулсан, санхүүгийн өргөн эрх мэдэлтэй.	Олон хүчний төлөөлөлөөс шүүхийн захиргааны байгууллага бүрдүүлсэн нь шүүх засаглалын бие даасан байдал, төрийн эрх мэдлийг хувирлах онолтой зөрчилдөж байна.
8. Ирландын Шүүхийн үйлчилгээний байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>a) Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах,</li> <li>b) Олон нийтэд шүүхийн талаар мэдээлэл өгөх,</li> <li>c) Шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах,</li> <li>d) Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;</li> <li>e) Шүүхээр үйлчлүүлж буй этгээдүүдийг таатай нөхцөл хангах.</li> </ul>	Илт ялгаатай, онцлог чиг үүрэг байхгүй.	Шүүхийн үйлчилгээний байгууллага нь дотоод бүтэц болох Зөвлөл нь өргөн эрх хэмжээтэй бөгөөд гол бодлогийг тодорхойлдог.	Ажиглагдаагүй.
9. Дани улсын шүүхийн зөвлөл	Ихэнх чиг үүрэг нь адилхан.	Илт ялгаатай, онцлог чиг үүрэг байхгүй.	Шүүхийн үйлчилгээний байгууллага нь дотоод бүтэц болох Зөвлөл нь өргөн эрх хэмжээтэй бөгөөд гол бодлогийг тодорхойлдог.	Ажиглагдаагүй.
10. АНУ –ын шүүхийн захиргааны байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>a) Шүүхийн бүтэц зохион байгуулалт, шүүхийн төсөв төсөвлөх,</li> <li>b) Шүүхийн байр, боловсон хүчнийг бүрдүүлэх,</li> <li>c) Хурал зохион байгуулах,</li> <li>d) Олон нийтийн мэдээллийн асуудлыг хариуцах,</li> <li>e) Сургалт, судалгаа явуулах, мэдээллийн технологийг хариуцах,</li> </ul>	Илт ялгаатай, онцлог чиг үүрэг байхгүй.	Тогтолцоо бүрдээд тогтвортой удаан хугацаан үйл ажиллагаа явуулсан, дотоод бүтцийн хувьд сайн зохион байгуулалттай.	Ажиглагдаагүй.

11. Канад ын шүүхийн захиргааны байгууллага

- а) Шүүхүүдийн хоорондын уялдаа холбоо, ажлыг хөнгөвчлөх, дэмжлэг үзүүлэх,
- б) Шүүхийн бие даасан, засгийн газраас хараат бус байдлыг нэмэгдүүлж, шүүхийн зохион байгуулалт, менежментийн асуудлыг хариуцах,
- в) Шүүх нь санхүүгийн хувьд хараат бус бие даасан байдлыг бий болгох.

а) Санхүү, мөнгөтэй холбоотой асуудлаар олон нийтэд тайлагнах ажлыг шүүхийн захиргаанаас гүйцэтгэх.

Байхгүй.

Ажиглагдаагүй.

